

**УВС ЧАЦАРГАНА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН**

ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 сарын 27 өдөр

Дугаар

08/27

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Увс чацаргана” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурал 2024 оны 04-р сарын 27 өдрийн 10 цагт Улаанбаатар хот БГД 26-р хороо 29/8 байр 1-1 тоотод болов.

Хуралд:

“Увс чацаргана” ХК-ийн нийт 379409 ширхэг хувьцаатайгаар хуралд хувьцаа эзэмшигч

С.Батболд /188300 ширхэг хувьцааны саналаар/

Д.Эрдэнэ /191109 ширхэг хувьцааны саналаар/

тус тус оролцов.

Хурал зохион байгуулах комисс хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хийж компанийн нийт гаргасан 713499 ширхэг саналын эрхтэй хувьцааны тоог 379409 ширхэг хувьцаагаар тогтоож хурлын ирц 53,1% байгааг мэдээлж компанийн тухай хуулийн 69.1 заасны дагуу хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлэхийг тооллогын комисс зөвшөөрөв.

Хурал 10:10 минутад эхлэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга А.Ариунсайн үг хэлэв.

- Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Компанийн ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай тогтоолд хурлыг удирдах даргаар Д.Эрдэнийг томилсон. Иймээс хурлын дарга хурлыг эхлүүлнэ үү.

Ингээд хурлын дарга Д.Эрдэнэ байраа эзлэв.

За та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Миний бие “Увс чацаргана” ХК-ийн ТУЗ-ийн дарга, хувьцаа эзэмшигч байна. Хурлыг дэгийг юуны өмнө танилцуулья.

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;
3. Бусад асуудал:

СОНССОН НЬ 1:

Хэлэлцэх асуудлын дагуу 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан болон компанийн товч танилцуулгыг уншиж танилцуулав.

“Увс чацаргана” ХК нь 1978 оноос хойш чацарганы үйлдвэрлэл эрхлэхээр байгуулагдсан бөгөөд 1988 он гэхэд нийт 480га талбайд 500,000 ширхэг чацарганы модтой, бүрэн механикжсан усалгааны систем, үерийн далангийн байгууламжтай, нийт 300-аад ажиллагсадтай , эрдэм шинжилгээний туршилт судалгааны төв болон өргөжсөн юм.

Монгол Улс зах зээлийн нийгэмд шилжсэн 1990-ээд оны үед тус байгууллага нь бусад аж ахуй нэгж , үйлдвэрүүдийн нэгэн адил зах зээлийн болон санхүүгийн хямралд өртөж их хэмжээгээр сүйдсэн юм.

Шинэчлэгдсэн компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь чацарганы аж ахуй юм.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга А.Ариунсайн Компанийн тухай хуульд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл, санхүүгийн жил дууссанаас хойш 50хоногийн дотор ногдол ашиг хуваарилах шийдвэрийг ТУЗ гаргана гэж заасны дагуу ТУЗ хуралдаж 1,116,700 төгрөгийн ашигтай ажилласан тул хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах боломжгүй гэж үзсэн.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн 2023 оны үйл ажилагааны болон санхүүгийн баталсугай.
2. Компани 2023 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулсаныг дурьдсугай.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхжүүлэх ажлыг ТУЗ-д даалгасугай.

ХУРАЛ УДИРДСАН ХУРЛЫН ДАРГА:  /У.ЭРДЭНЭ/

ПРОТОКОЛ БИЧСЭН:



/А.АРИУНСАЙН/